



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЗАВХАН АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2023 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

2023 оны батлагдсан төсвийг 6,948.9 сая төгрөг буюу 10.3 хувиар хэмнэсэн ч орон нутгийн тусгай сангуудын гүйцэтгэл хангалтгүй байна.



Улиастай хот
2024 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 70463612, цахим хаяг: batundraad@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Болдбаатар
Утас: 70463683, цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn
Аудитор: Г.Баасанжаргал
Утас: 99032514, цахим хаяг: baasanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу: Цахим хуудас www.audit.mn

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	2
АУДИТЫН ҮНДЭСЛЭЛ.....	3
БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ.....	5
1.1 Төсвийн суурь орлогын талаар:	5
1.2 ТЕЗ-ийн төсвийн орлогын талаар:	8
1.3 Төсвийн орлогын гүйцэтгэлийн талаар:.....	9
БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ	9
2.1 Төсвийн зардлын төлөвлөлтийн талаар:.....	9
2.2 Төсвийн зарлагын гүйцэтгэлийн талаар:	11
2.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар:	14
БҮЛЭГ 3. НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО, ЗАРДАЛ	17
3.1 Нэмэлт санхүүжилтийн орлого.....	17
БҮЛЭГ 4. АВЛАГА, ӨГЛӨГ	17
4.1 Авлага:.....	17
4.2 Өр төлбөр:	19
АУДИТЫН ДҮГНЭЛТ	21
ЗӨВЛӨМЖ.....	22
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	23
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР	24
АЛДАА ЗӨРЧЛИЙН БҮРТГЭЛИЙН МАЯГТ.....	25

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГХУССЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
СЯ	Сангийн яам
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс

ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт №1	Суурь орлогын төлөвлөлт, гүйцэтгэл	5
Хүснэгт №2	Татварын орлогын гүйцэтгэл	6
Хүснэгт №3	Төсвийн санхүүжилтийн эх үүсвэр /сангийн яам баталсан/	8
Хүснэгт №4	Төсвийн санхүүжилтийн эх үүсвэр /АИТХ баталсан/	8
Хүснэгт №5	Төсөв хоорондын шилжүүлгийн гүйцэтгэл	9
Хүснэгт №6	Аймгийн суурь зарлагын төлөвлөлт	10
Хүснэгт №7	Сумдын суурь зарлагын төлөвлөлт	10
Хүснэгт №8	Нийт зардлын гүйцэтгэл	11
Хүснэгт №11	Нийт төлөвлөгөө гүйцэтгэл хөтөлбөрөөр	13
Хүснэгт №14	Нэмэлт санхүүжилтийн орлого	17
Хүснэгт №15	Авлагын үлдэгдэл	17-18
Хүснэгт №17	Өр төлбөрийн үлдэгдэл	19
№	Тайлбар	Хуудасны дугаар
График №1	Төсвийн орлогын эх үүсвэр	8
График №2	Төрийн хэмнэлтийн тухай хууль	15

АУДИТЫН ҮНДЭСЛЭЛ

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

“Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл”-д аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Хамарсан хүрээ

Орон нутгийн төсөв санхүүжилт авсан, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуй нэгж, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, судалгаа, мэдээлэл, бусад баримт материалыг хамруулан аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС-100, АДБОУС-200, АДБОУС-2000, АДБОУС-4000.16-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-4:2020 “Төрийн аудит, Санхүүгийн аудитын тулгуур зарчим”, АДБОУС-1000-1810 “Санхүүгийн аудитын удирдамж” арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ыг мөрдөн холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, тодруулга, лавлагаа авах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан, нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашигласан.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

- Татварын ерөнхий хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Холбогдох бусад хууль, журам эрх зүйн акт

Хүндрэл бэрхшээл: Аймгийн Татварын газраас тайлан, мэдээ, судалгааг гаргасан холбогдох албан тушаалтнаас тайлбар тодруулга авахаар утсаар залгасан боловч утсаа авахгүй, татварын албаны ажилтнуудын хүнд суртал аудитын явцад хүндрэл учруулж байлаа.

Аудит хийсэн хугацаа, аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар хэрэгжүүлж, аудитор Г.Баасанжаргал 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн, 04 дүгээр сарын 19-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар Завхан аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 23,254.5 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 15,043.1 сая төгрөгөөр баталжээ. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 81 дүгээр тогтоолоор аймгийн төсөвт төвлөрөх татварын болон татварын бус орлогыг 4,929.1 сая төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс 3,520.7 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 89.1 сая төгрөгөөр, Дөрвөлжин, Тосонцэнгэл, Улиастай сумдаас аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 2,907.8 сая төгрөгөөр, 2023 онд аймгийн төсвөөс зарцуулах нийт зарлагыг 49,744.4 сая төгрөгөөр баталснаас сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 8,115.3 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардлыг 12,974.7 сая төгрөг, сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 8,089.2 сая төгрөг, төсөвт байгууллагуудад олгох санхүүжилтийг 20,565.2 сая төгрөгөөр тус тус баталсан байна. Сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 12,023.7 сая төгрөгөөр, нийт зарлагыг 17,954.5 сая төгрөгөөр баталсан байна.

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ

Аймгийн нийт татварын орлого төлөвлөгөөнөөс давж биелсэн боловч зарим нэр төрлийн татварын орлого тасарсан байна.

1.1 Төсвийн суурь орлогын талаар:

Аймгийн төсвийн суурь орлогын Сангийн яамны анх хянасан дүнг өмнөх оны төлөвлөгөөтэй харьцуулахад 2,267.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 5,106.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Хувь хүний орлогын албан татварын буцаан олголтод 2023 онд 1,116.6 сая төгрөг олгохоор төлөвлөж, татварын суурь орлогоос хасаж хянасан байна.

Суурь орлогын төлөвлөлт, гүйцэтгэл

Хүснэгт-1

/сая.төг/

Суурь орлого	2022 он			2023 он		
	Анх хянасан	Тодотгосон	Гүйцэтгэл	Анх хянасан	Тодотгосон	Гүйцэтгэл
Татварын орлого	17,340.00	17,246.00	18,944.70	14,643.60	14,418.60	18,719.40
Татварын бус орлого	963.6	963.6	2,103.80	1,298.50	1,420.30	1,937.30
ДҮН	18,303.60	18,209.60	21,048.50	15,942.10	15,838.90	20,656.70

Төрийн аудитын газраас 2023 онд 7 нэр төрлийн татварт 1,187.5 сая төгрөгийн орлого нэмэгдүүлэх санал оруулж, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2022 оны 10 дугаар тогтоолоор баталсан байна.

Орон нутгийн татварын орлого 2023 онд 16,736.2 сая төгрөг /татварын буцаан олголт 1,116.6 сая төгрөгийг хассан/ төвлөрсөн нь Сангийн яамны тодотгосон суурь орлогоос 897.2 сая төгрөгөөр буюу 5.3 хувиар, аймгийн ИТХ-ын нэмэлт даалгавар 1,187.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн дүнтэй харьцуулахад 4,418.2 сая төгрөг буюу 26.8 хувиар давж биелсэн байна.

Аймгийн ИТХ-аас нэмэлт даалгавраар өгсөн 7 нэр төрлийн орлогоос цалин хөлс, шагнал урамшуулал, улсын тэмдэгтийн хураамж, ойн нөөц ашигласны төлбөр, хадгаламжийн хүүгийн орлого, хүү, торгуулийн орлого 4,418.2 сая төгрөгөөр буюу 69.3 хувиар давж биелсэн. Харин Малын тоо толгойн албан татвар 129.5 сая төгрөгөөр тасарсан байна.

Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татварыг аймгийн төрийн аудитын газраас оруулсан саналаас аймгийн ИТХ-аар 216.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Татварын орлогын гүйцэтгэлийг харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-2

/сая.төг/

№	Татварын нэр төрөл	Төл /СЯ тодотгосон/	Нэмэлт даалгавар /АИТХ/	Э тайлан		Биелэлт /хувиар/	Татвар		Биелэлт /хувиар/
				Төл	Гүйц		Төл	Гүйц	
1	Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татвар	7,974.96	327.54	8,302.50	12,156.90	34.40	8,085.86	11,944.00	47.7
2	Үйл ажиллагааны орлого	400.00	0.00	400.00	514.70	22.2	400.00	448.12	12.0
3	Хөрөнгийн орлого /хадгаламжийн хүүгийн орлого/	1,100.00	50.00	1,150.00	187.40	-486.9	1,150.00	1,221.85	6.2
4	Шууд бус орлого /хувь хүнээс суутгасан суутгалын орлого/	200.00		200.00	86.40	-131.4	200.00	83.85	-58.0
5	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	2,950.00		2,950.00	1,523.40	-93.6	2,950.00	1,523.40	-48.3
6	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	517.70		517.70	988.30	47.6	517.70	943.34	82.2
7	Галт зэвсгийн албан татвар	60.00	0.00	60.00	54.80	-9.4	60.00	53.46	-10.9
8	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	390.00		390.00	477.00	18.2	390.00	475.10	21.8
9	Улсын тэмдэгийн хураамж	260.00	10.00	270.00	324.10	19.7	270.00	286.71	6.1
10	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	14.00		14.00	10.40	-34.6	14.00	10.51	-24.9
11	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	150.00		150.00	106.80	-40.4	150.00	104.70	-30.2
12	Газрын төлбөр	616.92		616.90	818.00	24.5	616.92	807.80	30.9
13	Дуудлага худалдаа				201.20	100.0			0.00
14	Ойн нөөц ашигласны төлбөр	310.00	40.00	350.00	373.20	16.9	350.00	365.11	4.3
15	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	10.00		10.00	514.90	98.0	10.00	430.55	4,205.4
16	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	320.00		320.00	233.80	-36.8	320.00	231.42	-27.6
17	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	10.00		10.00	4.30	-132.5	10.00	2.90	-70.9
18	Малын тоо толгойн албан татвар		842.40	815.40	722.40	100.0	842.40	712.92	-15.3
19	Хөрөнгө борлуулсны орлого	35.00	0.00	35.00	160.20	78.1	35.00	190.25	443.5
20	Нохойны албан татвар		10.00	0.40		0.00	0.00		0.0
Татварын орлогын дүн		15,318.58	1,279.94	16,561.90	19,458.20	21.2	16,371.88	19,835.99	21.1
21	Хүү, торгуулийн орлого /татварын бус орлого/	1,356.70	124.20	1,480.90	2,355.10	42.3	1,480.90	1,937.34	30.8
22	Бусад орлого	50.00	0.00	0.00	74.80	33.1	0.00	0.00	0.0
23	Төсөвт байгууллагын өөрийн орлого	13.60	75.50	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.0
Татварын бус орлогын дүн		1,420.30	199.70	1,480.90	2,429.90	41.5	1,480.90	1,937.34	30.8
Нийт татварын орлого		16,738.88	1,479.64	18,042.80	21,888.10	23.5	17,852.78	21,773.33	21.9
Буцаан олголт		(900.00)	-	(1,116.60)	(1,116.60)	19.4	(1,116.61)	(1,116.61)	0.0
Цэвэр дүн		15,838.88	1,479.64	16,926.20	20,771.50	23.7	16,736.17	20,656.72	23.4

Татварын орлого давж биелэхэд дараах нэр төрлийн орлогууд голлох нөлөө үзүүлжээ. Үүнд:

- Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татвар 47.7 хувиар давсан нь тайланд онд цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 82.2 хувиар давсан нь Тосонцэнгэл, Улиастай сумдад давж биелсэн нь гол нөлөө үзүүлж байна.
- Газрын төлбөр 30.9 хувиар давсан нь Алдархаан, Асгат, Баянхайрхан, Завханмандал, Отгон, Түдэвтэй, Ургамал, Эрдэнэхайрхан, Яруу сумдад давж биелсэн, бусад сумдад тасарсан байна.

- Хадгаламжийн хүүгийн орлогыг аймгийн татварын газар нь хөрөнгө борлуулсны орлогоор төлөвлөж байгаа нь аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэстэй ажлын уялдаа холбоогүй, төлөвлөлт үндэслэлгүй төлөвлөгдсөнөөс шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

Татварын орлогын нийт батлагдсан төлөвлөгөө 16,736.17 сая төгрөг байхад Сангийн яамны Э-тайлангаар 16,926.2 сая төгрөг буюу 190.03 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь татварын орлогын өөрчлөлтийг программд татахгүй байгаагаас шалтгаалж байна. Орлогын гүйцэтгэлийн тайланг татварын албаны мэдээнээс 114.8 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, татварын орлогын мэдээнээс 10 нэр төрөлд зөрсөн зөрчил давтагдан гарсан байна.

Мөн аймгийн ЗДТГ-ын СТСХэлтэс нь хадгаламжийн хүүгийн орлогыг хүү, торгуулийн орлогоор тайлагнасан нь аймгийн Татварын газартай ажлын уялдаа холбоогүй, төлөвлөлт үндэслэлгүй төлөвлөгдсөнтэй холбоотой байна.

Дээрх зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Тайлант онд төлөвлөсөн татварын орлогын төлөвлөгөөг биелүүлж, ажилласан ч зарим татварын орлогын төлөвлөгөө биелээгүй нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Шууд бус орлого буюу хувь хүнээс суутгасан суутгалын орлого биелээгүй нь төсөв байгууллагууд иргэдээс худалдан авалт хийхдээ И-баримт гаргуулан авч, хувь хүн орлогоо өөрсдөө тайлагнаж, үйл ажиллагааны орлогын албан татвар төлдөг болсонтой холбоотой байна.
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 48.3 хувиар тасарсан нь “Баян-айраг эксплорейшн” ХХК нь 2023 онд үйл ажиллагаагаа хэвийн явуулаагүйгээс орлого тасарсан байна.
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 24.9 хувиар тасарсан нь өмнөх онуудад аймгийн хэмжээнд сайжруулсан засмал зам барьсантай холбогдуулан 2022 онд тус орлогын төлөвлөгөөг нэмж төлөвлөсөн, 2023 онд төлөвлөгөөг бууруулж батлаагүй, төлөвлөлттэй холбоотой байна.
- Ус рашааны нөөц ашигласны төлбөр аймаг 27.7 хувиар тасарсан нь “Баян-айраг эксплорейшн” ХХК-аас аймагт орох орлого төвлөрөөгүйтэй холбоотой байна.
- Галт зэвсгийн албан татвар төлөвлөсөн хэмжээнд төвлөрөөгүй байна.
- Малын тоо толгойн албан татвар 15.3 хувиар буурсан нь малын татварыг оны эцэст тайлагнуулж, орлогыг төвлөрүүлдэгтэй холбоотой малын хорогдол их байгаа учраас малчдаас татвар хураахад хүндрэл гарсан тул тасарсан байна.

1.2 ТЕЗ-ийн төсвийн орлогын талаар:

Сангийн яамнаас аймгийн ТЕЗ-ийн 2023 онд бүрдүүлэх орлогыг анх 15,942.1 сая төгрөгөөр баталсан бөгөөд төсөвт тодотгол хийж, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн бүрдүүлэх орлогыг 103.2 сая төгрөгөөр бууруулжээ. 2023 оны батлагдсан орлогыг өмнөх онтой харьцуулахад 2,370.7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Төсвийн орлогын эх үүсвэр

Хүснэгт-3

/сая.төг/

д/д	Орлогын нэр төрөл	2021 он			2022 он			2023 он		
		Анх баталсан	Тодотгосон	Зөрүү	Анх баталсан	Тодотгосон	Зөрүү	Анх баталсан	Тодотгосон	Зөрүү
1	Татварын орлого	8,842.00	8,842.00	-	18,300.00	18,300.00	-	16,870.90	15532.50	1,338.40
2	Татварын бус орлого	533.6	533.6	-	800	800	-	1298.50	1420.30	-121.80
3	Санхүүгийн дэмжлэг	16,589.80	17,469.10	-879.3	17,976.50	14,834.70	-3,141.80	17,716.31	23,254.46	-5,538.15
4	Орон нутгийн хөгжлийн сан	5,721.00	5,987.60	-266.6	7,829.50	7,184.60	-644.9	11,932.59	15,043.06	-3,110.47
5	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	-	-	163.6	89.1	74.5	89.1	89.1	0.00
ДҮН		31,686.40	32,832.30	-1,145.90	45,069.60	41,208.40	-3,712.20	47,907.40	55,339.42	-7,432.02

График-1

/сая.төг/



Аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 81 дүгээр тогтоолоор 2023 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг дор дурдсанаар тодотгон баталжээ.

Хүснэгт-4

/сая.төг/

№	Төсвийн эх үүсвэр	Сангийн яам /тодотгол/	АИТХ /тодотгол/	Зөрүү
1	Татварын болон татварын бус орлого	15,838.9	16,952.8	1,113.9
2	Аймгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	23,254.5	23,254.5	0.0
3	ОНХС-д олгох орлогын шилжүүлэг	15,043.1	15,043.1	0.0
4	Төсөвт байгууллагын өөрийн орлогоос	13.6	89.1	75.5
5	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	0.0	3,520.7	3,520.7
ДҮН		54,150.0	58,860.1	4,710.1

Орон нутгийн суурь орлогыг Сангийн яамны баталсан дүнгээс 4,710.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь татварын болон татварын бус орлогыг 1,113.9 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 75.5 сая төгрөгөөр, урьд оны үлдэгдлийг 3,520.7 сая төгрөгийг тус тус нэмэгдүүлжээ. Урьд оны үлдэгдэл 3,520.7 сая төгрөгийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад 2,576.6 сая төгрөгийг, аймгийн ОНХС-д 681.3 сая төгрөгийг, аймгийн ИТХ-д 203.8 сая төгрөгийг, аймгийн ЗДТГ-т 59.0 сая төгрөгийг тус тус зарцуулахаар баталсан байна.

Сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор сумын төсвийн орлогыг 8,838.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталж, нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 67,698.9 сая төгрөгөөр төлөвлөжээ.

1.3 Төсвийн орлогын гүйцэтгэлийн талаар:

Улсын төсөв, орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээр нийт 207.1 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсон байна.

Төсөв хоорондын шилжүүлгийн гүйцэтгэл

№	Төсвийн эх үүсвэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аймгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	23,254.5	23,254.7	0.2
2	ОНХС-д олгох орлогын шилжүүлэг	15,043.1	14,836.0	(207.1)
ДҮН		38,297.5	38,090.7	(206.9)

Гүйцэтгэлээр улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 23,254.7 сая төгрөг, ОНХС-д олгох орлогын шилжүүлгээс 14,836.0 сая төгрөг, татварын болон татварын бус орлогоос 21,413.6 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 2,090.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ

Аймгийн төсвийн суурь зардлыг Сангийн яамны хянасан зардлын хязгаараас илүү төлөвлөсөн байна.

2.1 Төсвийн зардлын төлөвлөлтийн талаар:

Сангийн яам орон нутгийн суурь зарлагыг сая 39,093.5 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг 15,043.1 сая төгрөгөөр тодотгон баталсан нь анх баталснаас 8,648.6 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ.

ЗАВХАН АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 81 дүгээр тогтоол, сумдын ИТХ-ын тогтоолоор нийт зарлагыг 67,698.9 сая төгрөгөөр баталсан нь Сангийн яамны баталсан суурь зарлагаас 15,061.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ. Энэхүү зардлыг урьд оны үлдэгдэл болон татварын нэмэлт даалгаврын орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Аймгийн суурь зарлагын төлөвлөлт

Хүснэгт-6

/сая.төг/

д/д	Зардлын төрөл	Сангийн яам /год/	АИТХ /год/	Зөрүү
1	Аймгийн ИТХ	472.5	1,021.2	548.7
2	Аймгийн ЗДТГ	7,276.6	4,164.1	-3,112.5
3	Ойн анги	151.9	223.5	71.6
4	Байгаль орчны газар	1,326.00	1,441.5	115.5
5	Аймгийн халамжийн сан	115.6	115.6	-
6	Санхүүгийн хяналт аудитын алба	182.5	265.5	83
7	Орон нутгийн өмчийн газар	161.2	300.4	139.2
8	Хүүхдийн цэцэрлэг /тогтмол зардал/	2,376.8	1,637.2	-739.6
9	Ерөнхий боловсролын сургууль /тогтмол зардал/	7,450.1	6,313.5	-1,136.6
10	Эрүүл мэндийн салбар /тогтмол зардал/	1,023.5	745.3	-278.2
11	Соёлын салбарын тогтмол зардал	1,852.9	1,311.2	-541.7
12	Мэргэжлийн боловсролын байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	713.3	678.2	-35.1
13	Биеийн тамир спортын газар	798.8	876.7	77.9
14	Ахмад настны хөгжил хамгаалал	95.6	106.4	10.8
15	Сумдад олгох санхүүгийн дэмжлэг		8,115.3	8,115.3
16	Мал эмнэлгийн үйлчилгээ, эм бэлдмэл	506.9	506.9	-
17	Засаг дарга	1,128.5	840.3	-288.2
18	Хотын нийтийн тээврийн хөнгөлөлт	12.9	12.9	-
19	Сонгуулийн үр дүнд чөлөөлөгдсөн улс төрийн албан хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмж	-	4.8	4.8
20	Сумдын ИТХ	2,532.8		-2,532.8
21	Сумдын ЗДТГ	8,280.7		-8,280.7
22	Хот тохижилт үйлчилгээний албан	552.4		-552.4
Дүн		37,011.5	28,680.5	-8,331.0
1	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	15,043.1	15,724.4	681.3
2	Их засварын зардал	1,294.5	1,294.5	-
3	Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардал	-	3,393.0	3,393.0
4	Авто замын сан	787.5	652.0	-135.5
ДҮН		17,125.1	21,063.9	3,938.8

Сумдын суурь зарлагын төлөвлөлт

Хүснэгт-7

/сая.төг/

д/д	Зардлын төрөл	АИТХ /год/	СИТХ	Зөрүү
1	Сумдын ИТХ	1,465.7	2,912.3	1,446.6
2	Сумдын ЗДТГ	12,685.9	14,841.8	2,155.9
3	Улиастай сумын ХТҮА	1,269.9	1,269.9	-
4	ОНХС	8,089.2	12,073.7	3,984.5
5	Хоршоо хөгжүүлэх сан	-	3,033.8	3,033.8
Дүн		23,510.7	34,131.5	10,620.8

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн зарлагын төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 81 дугаар тогтоолоор 681.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 7,635.2 сая

төгрөгөөр, аймгийн ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлгийг 1,815.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 8,089.1 сая төгрөгөөр тодотгожээ.

2.2 Төсвийн зарлагын гүйцэтгэлийн талаар:

Нийт зардлын гүйцэтгэл

Хүснэгт-8

/сая.төг/

Д/д	Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэл/+/ хэтрэлт/-	Эзлэх хувь
1	НИЙТ ЗАРДАЛ	67,698.90	60,749.95	6,948.95	89.74
2	УРСГАЛ ЗАРДАЛ	39,616.76	37,422.30	2,194.46	94.46
3	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,805.93	14,381.66	424.27	97.13
4	Ажил олгогчоос төлөх НДШ	1,853.15	1,808.55	44.60	97.59
5	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,854.80	11,463.18	391.62	96.70
6	Хангамж бараа материалын зардал	1,097.32	1,029.99	67.33	93.86
7	Норматив зардал	175.74	175.74	-	100.00
8	Эд хогшил урсгал засварын зардал	712.73	656.23	56.50	92.07
9	Томилонт зочны зардал	377.55	355.67	21.88	94.20
10	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,336.25	3,171.81	164.44	95.07
11	Бараа үйлчилгээний бусад зардал	3,917.89	3,479.73	438.16	88.82
12	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР	568.71	-	568.71	-
13	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	568.71	-	568.71	-
14	ТАТААС	12.95	12.95	-	100.00
15	Хувийн хэвшлийн байгууллагад өгөх татаас	12.95	12.95	-	100.00
16	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	903.74	886.79	16.95	98.12
17	Бусад урсгал шилжүүлэг буюу тэтгэмж урамшуулал	903.74	886.79	16.95	98.12
18	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25,048.36	21,700.93	3,347.44	86.64
19	Бусад хөрөнгө	25,048.36	21,700.93	3,347.44	86.64
20	Эргэж төлөгдөх зээл	3,033.77	1,626.72	1,407.06	53.62

Цалингийн зардал: Цалингийн зардлыг анх 11,837.0 сая төгрөгөөр баталсныг тодотголоор 2,968.9 сая төгрөгөөр нэмж, 14,805.93 сая төгрөгөөр баталжээ. Гүйцэтгэлээр 14,381.66 сая төгрөгийг зарцуулж, цалингийн зардлыг 424.3 сая төгрөгөөр буюу 2.87 хувиар хэмнэсэн байна. Энэ нь нийтлэг үйлчилгээний ажилчдын цалин хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал: Төсөвт байгууллагуудын байр ашиглалттай холбоотой зардлыг анх 11,548.3 сая төгрөгөөр баталж, тодотголоор 306.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 11,854.8 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

ЗАВХАН АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Хүснэгт-9

/сая.төг/

№	Зардлын ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Эзлэх хувь
1	Гэрэл цахилгаан	989.23	816.70	172.54	82.56
2	Түлш халаалт	10,458.87	10,265.71	193.16	98.15
3	Цэвэр бохир ус	400.69	367.77	32.92	91.78
4	Байрны түрээс	6.00	13.00	(7.00)	216.67
Дүн		11,854.80	11,463.18	391.62	96.69

Бичиг хэргийн зардал: Бичиг хэргийн зардлыг анх 126.8 сая төгрөгөөр баталж, тодотголоор 7.8 сая төгрөгөөр нэмэгдсэн, 134.6 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 138.2 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 3.6 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх”, 15.2.4 “бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх” гэсэн заалтыг хангахгүй байна.

Тээвэр, шатахууны зардал: Тайлант онд тээвэр, шатахууны зардлыг 796.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 743.9 сая төгрөг зарцуулж, зардлыг 52.8 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Томилолтын зардал: Томилолтын зардлыг тайланд онд 377.5 сая төгрөгөөр баталснаас 355.6 сая төгрөгийг зарцуулж, 21.9 сая төгрөгийг хэмнэжээ.

Урсгал шилжүүлэг: Бусад урсгал шилжүүлэг 903.6 сая төгрөгөөр батлагдаж, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж 115.6 сая төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалд 15.6 сая төгрөг, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулалд 94.3 сая төгрөг, тэтгэвэр гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 547.5 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд 113.9 сая төгрөг зарцуулж, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал буюу сонгуулийн үр дүнгээр ажлаас чөлөөлөгдсөн улс төрийн албан хаагчид олгох нэг удаагийн тэтгэмжээс 16.9 сая төгрөгийг хэмнэжээ.

Хүснэгт-10

/сая.төг/

№	Зардлын ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Эзлэх хувь
1	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	115.6	115.6	0	100.00
2	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	18	15.5	2.5	86.11
3	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	101.9	94.3	7.6	92.54
4	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	553.9	547.4	6.5	98.83
5	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	114.2	113.9	0.3	99.74
Дүн		903.60	886.70	16.90	98.13

Хөрөнгийн зардал: Тус зардлыг өмнөх оноос 11,788.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 25,048.3 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 21,700.9 сая төгрөгийг зарцуулж, 3,347.4 сая төгрөгийн зардал хэмнэгдсэн байна.

Нийт төлөвлөгөө гүйцэтгэл, хөтөлбөрөөр

Хүснэгт-11

/сая.төг/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	3,933.5	3,605.7	327.8	91.7
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	19,300.9	18,417.4	883.5	95.4
3	Мэргэжлийн хяналт	265.5	263.0	2.5	99.1
4	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	300.4	293.3	7.1	97.6
5	Орон нутгийн зорилгод хөрөнгө оруулалт	24,396.4	21,206.6	3,189.8	86.9
6	Мал аж ахуйг хөгжүүлэх	506.9	506.8	0.1	100.0
7	Авто тээврийн хяналт, зохицуулалт, үйлчилгээ нийтийн тээвэр	12.9	12.9	-	100.0
8	Авто зам	651.9	494.4	157.5	75.8
9	Ойжуулалт	223.5	215.2	8.3	96.3
10	Хүрээлэн буй орчны бодлого удирдлага	1,441.5	1,439.4	2.1	99.9
11	Хот байгуулалт, тохижилт	1,269.9	1,269.9	-	100.0
12	Биеийн тамир спорт	893.4	843.2	50.2	94.4
13	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	747.5	712.5	35.0	95.3
14	Соёл урлаг	1,320.3	1,241.7	78.6	94.0
15	Сургуулийн өмнөх боловсрол	1,644.9	1,589.3	55.6	96.6
16	Ерөнхий боловсрол	6,286.7	6,113.1	173.6	97.2
17	Мэргэжлийн боловсрол	678.2	676.8	1.4	99.8
18	Нийгмийн халамж	115.6	115.6	-	100.0
19	Ахмад настны хөгжил хамгаалал	106.4	106.4	-	100.0
20	Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид	3,033.8	1,626.7	1,407.1	53.6
21	Гүйцэтгэх засаглалын удирдлага	568.7	-	568.7	-
Дүн		67,698.9	60,749.9	6,949.0	

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 60,749.9 сая төгрөг буюу 89.7 хувьтай байна. ТЭЗ нь 2023 оны батлагдсан төсвийг 6,948.9 сая төгрөг буюу 10.3 хувиар хэмнэсэн байна. Үүний 68.4 хувь буюу 4,753.1 сая төгрөг нь орон нутгийн тусгай сангуудтай холбоотой байна. Тухайлбал орон нутгийн тусгай сангуудын төлөвлөлт бодитой бус, Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт гэрээний хугацаанд төлөгдөхгүй, зарим сумд тайлант онд зээл олгоогүй, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлээгүй зэрэг нь нөлөөлж байна гэж үзлээ. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хэтрэлт, хэмнэлтийг харахад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд ТШЗ-чид байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэсэн байна.

Хүснэгт-12

/сая.төг/

Д/д	Сумдын нэр	Орон нутгийн хөгжлийн сан		Зөрүү	Хоршоог хөгжүүлэх сан		Зөрүү	Орон нутгийн хөгжлийн сан биелэлтийн хувь	Хоршоог хөгжүүлэх сангийн биелэлтийн хувь
		Төл	Гүйц		Төл	Гүйц			
1	Алдархаан	558.9	279.2	279.6	249.7	0.1	249.6	49.96	0.04
2	Тосонцэнгэл	1,801.9	1,614.8	187.1	150.0	93.5	56.5	89.61	62.30
3	Дөрвөлжин	822.0	486.2	335.7	100.0	63.5	36.5	59.15	63.48
4	Их-Уул	855.5	814.7	40.8	216.1	46.2	169.8	95.23	21.40
5	Отгон	506.0	261.8	244.2	100.0	57.5	42.5	51.74	57.51
6	Цэцэн-Уул	354.5	159.5	195.0	89.5	0.1	89.4	44.99	0.11
7	Тэлмэн	539.2	417.2	122.0	123.0	62.3	60.7	77.38	50.66
8	Сонгино	498.1	448.7	49.3	116.4	68.5	47.9	90.10	58.83
9	Улиастай	1,057.1	1,026.0	31.0	400.0	201.2	198.8	97.06	50.30
10	Цагаанчулуут	224.0	196.2	27.8	130.0	43.8	86.2	87.57	33.73
11	Эрдэнэхайрхан	494.4	266.6	227.7	162.6	91.4	71.2	53.93	56.19
Дүн		7,711.6	5,971.1	1,740.5	1,837.3	728.1	1,109.2	2,849.67	
12	Завхан шууд	За. Засаг дарга		Зөрүү	За.Орон нутгийн хөгжлийн сан		Зөрүү	За.Засаг даргын нөөц хөрөнгийн биелэлтийн хувь	За.Орон нутгийн хөгжлийн сангийн биелэлтийн хувь
		2,855.32	1,998.99	856.34	7,635.23	7,178.39	456.84	70.01	94.02
Дүн		2,855.32	1,998.99	856.34	7,635.23	7,178.39	456.84	1,313.17	
Нийт дүн		10,566.90	7,970.09	2,596.82	9,472.52	7,906.49	1,566.03	4,162.85	

Аудитын илрүүлэлт:

Аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудын төлөвлөлт, гүйцэтгэлийг хангаж ажиллах, Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг бодитой төлөвлөж, тухайн оны төсвийг баталж байх шаардлагатай байна.

Дээрх зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

2.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар:

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”, А/89 дүгээр тушаалаар баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ын хэрэгжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын хүрээнд үзэхэд Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн 94.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 29.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, 13.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 51.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн:

- ✓ 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг зөрчин цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас

бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авсан;


- ✓ 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3, 12.1.4 дахь заалтуудыг зөрчин албан хаагчдын гар утасны төлбөр, хэвлэл захиалгын төлбөр, нутгийн зөвлөлийн уулзалт, золгуут хийх арга хэмжээ зэрэг хуулиар зөвшөөрөөгүй бусад зардалд гаргасан;
- ✓ 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг зөрчин цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авалт хийсэн;
- ✓ 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.4, 15.1.5, 15.1.7 дахь заалтуудыг зөрчин хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгосон, Засаг даргын нөөц хөрөнгөөс телевизийн нэвтрүүлэг, сурталчилгаа, бэлэг дурсгалын зүйл худалдан авсан, чихэр, жимс зэрэгт зарцуулсан;
- ✓ 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалтыг зөрчин албан хаагчдыг чадавхжуулах сургалтын цахим хэлбэрт шилжүүлээгүй улмаас сургалтын төлбөр, автобус унааны зардал гаргасан зөрчлүүд байна.

Хүснэгт-13

/сая.төг/

Аудит хийсэн хэлбэр	Акт		Албан шаардлага		Зөвлөмж		Нийт тоо	Нийт мөнгөн
	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн		
Дүгнэлт гаргасан	6	13.8	10	45.6	3	19.3	19	78.7
Түүвэрт хамруулсан	1	0.1	3	6.2	3	9.9	7	16.2
Дүн	7	13.9	13	51.8	6	29.2	26	94.9

График-2



Төрийн хэмнэлтийн бодлогыг төрийн аудиттай уялдуулах замаар аудитын явцад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахаар нийт 73 эрсдэлээс тухайн байгууллагуудад хамаарал бүхий эрсдэлүүдийг сонгож, төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг шалгасан.

Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан автомашины хязгаарлалтын хэрэгжилтийг шалгахад 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 4 дүгээр тэмдэглэлд орон нутгийн өмчит байгууллагаас татан төвлөрүүлсэн автомашиныг цаашид зайлшгүй шаардлагатай байгаа орон нутгийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэх, худалдах, актлах ажлыг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт мэдэгдэл хүргүүлсэн байна. Үүнтэй холбоотой ОНӨГ нь аймгийн хэмжээнд 49 автомашин татан төвлөрүүлэхээс аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагаас 14 автомашин, сумдын ЗДТГ-аас 14 автомашин нийт 28 автомашиныг битүүмжилсэн байна. 2023 онд дуудлага худалдаагаар 14 автомашин оруулж 37.2 сая төгрөгийг ОНТ-т төвлөрүүлсэн байна.

Хүснэгт-14

/сая.төг/

Д/д	Хөрөнгийн нэр төрөл	Ашиглалтад орсон он	Балансын үнэ /төгрөг/	Зарсан үнэ	Балансад бүртгэлтэй байгууллагын нэр
1	Хогны машин	2011.06.30	13.41	2.00	Түдэвтэй сумын
2	УАЗ-39094-Фермер- МЭҮТ	2012-02-29	19.90	1.50	Сонгино ЗДТГ
3	Маяты 2	2013-06-28	17.00	1.45	
4	Трактор / ХАА /	2013-06-28	8.20	1.50	
5	УАЗ - 31519- Хантер	2013-07-30	23.53	2.00	
6	УАЗ-Фермер	2012.01.31	19.90	1.50	Нөмрөг ЗДТГ
7	УАЗ-3909- Фермер	2012.01.01	19.99	1.50	Яруу сум ЗДТГ
8	Авто ачигч ковш	2013.05.31	19.20	2.50	Тэлмэн ЗДТГ
9	Уаз 31512 автомашин	2015.05.29	33.00	1.50	
10	УАЗ-469 машин	2013.09.01	20.50	1.50	Тосонцэнгэл ЗДТГ
11	УАЗ-31412	2012.01.25	19.90	1.50	
12	УАЗ фургон	2010	18.50	1.20	Дөрвөлжин сумын
13	Lexus -470	2018	23.40	15.00	Аймгийн ИТХ
14	Nissan X Trgal/56-18 Зан /	2020	16.31	2.55	Улиастай сум
Нийт дүн			272.74	37.20	

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолын дагуу Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчит хуулийн этгээдээс татан төвлөрүүлсэн Фургон автомашиныг Эрүүл мэндийн газар, Түдэвтэй, Сонгино, Тэлмэн сумдын Эрүүл мэндийн төвд, суудлын автомашиныг Баянтэс, Дөрвөлжин, Завханмандал, Цагаанчулуут сумдын ЗДТГ, аймгийн ИТХ зэрэг байгууллагуудад тус тус шилжүүлэн өгч, баланст тусган ашиглалтын гэрээ байгуулан ажиллаж байна.

Дээрх ажлыг хэрэгжүүлснээр байгууллагуудын автомашины ашиглалтад ахиц гарах, шатахууны зардал хэмнэх, илүүдэлтэй ашиглалтгүй хөрөнгийг худалдсаны дүнд төсөвт тодорхой хэмжээний орлого орсон зэрэг нь урьд оноос тодорхой үр нөлөө гарсан байна.

Мөн аймгийн хэмжээнд тээврийн хэрэгслийн улсын дугаарыг хөх дэвсгэртэй болгох 238 автомашин байгаагаас 2023 онд 59 автомашиныг хөх дэвсгэртэй

болгосон бөгөөд үлдсэн 179 автомашиныг 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор болгохоор төлөвлөсөн байна.

БҮЛЭГ 3. НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО, ЗАРДАЛ

Нэмэлт санхүүжилтийн дансанд 957.8 сая төгрөгийн өмнөх оны үлдэгдэлтэй байсан, тайлант онд 6,410.5 сая төгрөгийн орлого төвлөрч, бараа үйлчилгээний зардалд 6,001.8 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 14.2 сая төгрөг, хөрөнгийн зардалд 100.1 сая төгрөг зарцуулж, 640.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэн, 611.8 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

3.1 Нэмэлт санхүүжилтийн орлого

Хүснэгт-14 */сая.төг/*

Д/д	Орлогын төрөл	Өмнөх он	Тайлант он
1	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10.0	
2	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,691.5	267.4
3	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,486.8	6,143.1
ДҮН		5,188.3	6,410.5

Нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн ХО-ын төсөл арга хэмжээний санхүүжилт, ОНХС-аас эрх шилжсэн ажлын санхүүжилт, ЗД-н нөөц сангаас байгууллагуудад олгосон дэмжлэг, нийтлэг үйлчилгээний албан хаагчдын цалин шимтгэлийн зардал зэрэг санхүүжилтүүд дамжсан байна.

БҮЛЭГ 4. АВЛАГА, ӨГЛӨГ

4.1 Авлага:

Авлагын дансны эхний үлдэгдэл 5,675.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 6,274.9 болж, 599.8 сая төгрөгөөр өссөн бөгөөд нийт авлагын 84.1 хувийг Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн авлага эзэлж байна.

Авлагын үлдэгдэл

Хүснэгт-15 */сая.төг/*

Авлагын ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт(-)	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбоотой авлага	5.8	7.23	1.43	0.12
Төлбөртэй үйлчилгээний авлага	100.1	179.5	79.4	2.90
Байгууллагаас авах авлага	282.5	611.95	329.45	9.70
Дансны авлага /ТӨҮГ/	83.61	196.38	112.77	3.12

ЗАВХАН АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Татвар НДШ -ийн авлага /ТӨҮГ/	0.7	0.7	0	-
Татаас санхүүжилтийн авлага	0	0	0	-
Хувь хүнээс авах авлага	5,202.42	5,279.14	76.72	84.13
Нийт дүн	5,675.13	6,274.90	599.77	100

Нийт авлагын үлдэгдлийн 92.9 хувийг төсөвт байгууллага, 0.7 хувийг төсөл сан, 2.9 хувийг төрийн сан, 3.5 хувийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага тус тус эзэлж байна.

Хүснэгт-16

/сая.төг/

Байгууллагын төрлөөр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт(-)	Дүнд эзлэх хувь
Төсөвт байгууллага	5,422.7	5,833.1	410.4	92.90
Төсөл сан	41.5	41.5	0.0	0.70
Төрийн сан	100.0	179.4	79.4	2.90
ОНӨААН	111.0	220.9	109.9	3.50
Дүн	5,675.13	6,274.90	599.77	100

Төсөвт байгууллагын авлага

Төсөвт байгууллагын 5,833.1 сая төгрөгийн авлагын 5,210.0 сая төгрөг буюу 89.3 хувь нь Хоршоо хөгжүүлэх сангийн, 403.1 сая төгрөг буюу 6.9 хувь нь сумдын ОНХС-ийн, 220.0 сая төгрөг буюу 3.8 хувь нь орон нутгийн төсөвт байгууллагуудын авлага байна.

Төрийн сангийн авлага

Аймгийн төрийн санд “Амь-Ус” ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 1,304.4 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрөөс тайлант онд 79.4 сая төгрөгийг орон нутагт олгох орлогоос барагдуулж, тус аж ахуйн нэгжээс авахаар авлага үүсгэжээ.

Төсөл сангийн авлага

Төсөл сангийн 41.5 сая төгрөгийн авлага нь Орон нутгийн хөрөнгө оруулалтаар он дамжин хийгдсэн ажлын техник хяналтын зардлыг барьцаа хөрөнгийн данснаас зарцуулсныг аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас барьцаа хөрөнгийн дансанд буцаан төвлөрүүлэх авлага байна.

ОНӨҮГ-ын авлага

ОНӨҮГ-ын авлага өмнөх оноос 109.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь “Амь-Ус” ХХК-ийн авлага 101.8 сая төгрөгөөр , “Тосон-очирт хайрхан” ОНӨААТҮГ-ын авлага 10.3 сая төгрөгөөр, Баруун бүсийн олимпод бэлтгэх төв 0.1 сая төгрөгөөр нэмэгдсэн ба Очир илч ХХК-ийн авлага 3.1 сая төгрөгөөр буурсан байна. Тус авлага нь ОНӨҮГ-уудын үйл ажиллагааны хүрээнд бий болсон байна.

4.2 Өр төлбөр:

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 1.798.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 2,181.7 сая төгрөг төгрөг болж, 383.7 сая төгрөгөөр буурсан байна.

Өр төлбөрийн үлдэгдэл

Хүснэгт-17

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр	493.5	877.2	383.7	40.2
Ажилчидтай холбогдсон өглөг	24	28.3	4.3	1.3
Бараа үйлчилгээний зардлын өглөг	28.9	57.6	28.7	2.6
Хувь хүмүүст төлөх өглөг	4.3	7.3	3	0.3
Байгууллагад төлөх өглөг	95.4	297.7	202.3	13.6
Татварын өглөг /ТӨҮГ/	69.7	190.9	121.2	8.8
НДШ өглөг /ТӨҮГ/	24.5	15.9	-8.6	0.7
Данс өглөг /ТӨҮГ/	92.6	125.4	32.8	5.7
Урьдчилж орсон орлого	154.2	154.2	0	7.1
Бусад урьдчилж орсон орлого	154.2	154.2	0	7.1
Урт хугацаат өр төлбөр	1,304.40	1,304.40	0	59.8
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	1,304.40	1,304.40	0	59.8
Дүн	1,798.00	2,181.70	383.7	100.0

Хүснэгт-18

/сая төгрөг/

Байгууллагын төрлөөр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төсөвт байгууллага	138	368	230	16.9
ОНӨААН	1,660.00	1,813.70	153.7	83.1
Дүн	1,798.00	2,181.70	383.7	100.0

Богино хугацаат өр төлбөр

Богино хугацаат өр төлбөр 877.2 сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд 368.0 сая төгрөг буюу 41.9 хувь нь төсөвт байгууллагын, 355.1 сая төгрөг буюу 58,1 хувь нь орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн өр төлбөр байна. Төсөвт байгууллагын өр төлбөр өмнөх оноос 230.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Улиастай сумын Хот тохижилт үйлчилгээний алба тайланд 400.0 сая төгрөгөөр барилга худалдан авсан ба 200.0 сая төгрөгийг нь дараа онд төлөхөөр өглөгөөр тусгасан нь нөлөөлсөн байна.

Урт хугацаат өр төлбөр

Урт хугацаат өр төлбөрийн эхний үлдэгдэл 1,304.4 сая төгрөг бөгөөд тайлант онд нэмэгдээгүй байна. Тус өглөг нь Азийн хөгжийн банкнаас нийтийн ахуй үйлчилгээг дэмжих чиглэлээр “Амь-Ус” ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн авсан урт хугацаат зээл бөгөөд 20 гаруй жилийн насжилттай өглөг байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2023 оны батлагдсан төсвийг 6,948.9 сая төгрөг буюу 10.3 хувиар хэмнэсэн байна. Үүний 68.4 хувь буюу 4,753.1 сая төгрөг нь орон нутгийн тусгай сангуудтай холбоотой бөгөөд орон нутгийн сангуудын төлөвлөлт бодитой бус, Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт гэрээний хугацаанд төлөгдөхгүй, зарим сумд тайлант онд зээл олгоогүй, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаандаа хэрэгжүүлээгүй, санхүүжилтийг олгоогүй байгаа нь нөлөөлсөн байна.
2. Тайлант оны татварын орлогын гүйцэтгэлийг Сангийн яамны Э-тайланд 20,771.5 сая төгрөгөөр тайлагнасан бол аймгийн Татварын хэлтсийн 2023 оны мэдээгээр татварын орлогын гүйцэтгэлийг 20,656.72 /буцаан олголт хассан дүнгээр/ сая төгрөгөөр тайлагнаж, татварын албаны мэдээнээс 114.8 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, орлогын тайлан, татварын орлогын мэдээнээс 10 нэр төрөлд зөрсөн зөрчил нь өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил давтагдан гарсан байна.
3. Аймгийн ЗДТГ-н Санхүү төрийн сангийн хэлтэс нь хадгаламжийн хүүгийн орлогыг хүү, торгуулийн орлогоор тайлагнаж аймгийн Татварын газартай ажлын уялдаа холбоогүй, төлөвлөлтийг үндэслэлгүй төлөвлөсөн байна.
4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудтай холбоотой 94.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд өмнөх оны зөрчлөөс 67.8 хувиар буурсан нь тус хуулийн хэрэгжилт ахицтай харагдаж байна. Мөн тус хуулийг хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчит хуулийн этгээдээс татан төвлөрүүлсэн нь байгууллагуудын автомашины ашиглалтад ахиц гарах, шатахууны зардал хэмнэх, илүүдэлтэй ашиглалтгүй хөрөнгийг худалдсаны дүнд төсөвт тодорхой хэмжээний орлого орсон зэрэг нь урьд оноос тодорхой үр нөлөө гарсан байна гэж дүгнэлээ.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ

1. Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийг бодитой төлөвлөж, зээлийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу гэрээний хугацаанд төлүүлэх, хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах;
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гэрээний хугацааг тухайн төсөл арга хэмжээ хэрэгжих боломжтой, дулааны улиралд гүйцэтгэхээр төлөвлөн байгуулж, төсөл арга хэмжээг чанартай, үр дүнтэй хэрэгжүүлж, гүйцэтгэлийг бүрэн хангаж ажиллах;
3. Тусгай сангуудын төлөвлөлтийг бүрэн хангаж, үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавьж, арга зүйгээр хангаж ажиллах;

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн биелэлтийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор ирүүлэх;

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



МОНГОЛ УЛС
ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

81090 Улнастай, Завхан аймаг
Утас: 7575-1155, Факс: 7046-2550
И-мэйл: zavkhan.zdtg@gmail.com

2024.04.29 № 1/415

танай _____ -ны № _____ т

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэл, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж санал хүргүүлж байна.

1. Аудитын илрүүлэлт хэсэгт тусгагдсан зөрчлийг арилгах, залруулах боломжгүй байх тул 2024 оны төсвийн жилд зөрчлийг давтахгүй байх зорилго тавин ажиллаж байна.
2. Журмын дагуу хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох, хяналт тавих эрх, үүргийн хүрээнд сумдын засаг дарга нарт зөвлөмж өгч ажиллана уу.

ДАРГА  Г.ӨНӨРБАЯР



Г. Баасанпургал

Тайланг тусгай
Орлолт

8109060177

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Аймгийн Засаг даргаас ирсэн 2 асуудалд тайлбар санал ирүүлснийг удирдлагын зөвлөлөөр хэлэлцэн:

1. Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргаж татварын орлогын гүйцэтгэлийг 10 нэр төрөлд татварын газрын мэдээнээс 114.8 сая төгрөгөөр зөрүүтэй болон хадгаламжийн хүүгийн орлогыг хүү торгуулийн орлогоор тайлагнасан учир саналыг үндэслэн хугацааг хойшлуулан татварын орлогыг нэр төрлөөр зөв ангилж бүртгэн, татварын газартай хамтран ажиллаж, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор ирүүлэх албан шаардлагыг өгөхөөр шийдвэрлэлээ.
2. Сумдын Засаг дарга нарт тусгай сангуудын төлөвлөлтийг бүрэн хангаж, үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавьж, арга зүйгээр хангаж ажиллахыг нэмж оруулах шийдвэр гаргалаа.

АЛДАА ЗӨРЧЛИЙН БҮРТГЭЛИЙН МАЯГТ

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн бүртгэлийн маягт

Аудитын нэр:
Завхан аймгийн Засаг даргын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл дүнмэлт өгөх аудит

Аудитын код:
3AA-302401AAA-CTA-TE3

Байгууллагын нэр: Завхан аймаг дахь Төрийн аудитын газар

2024.04.29

№	Аудитын чиглэлт асуулт	Алдаа зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая.төг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгалдагч байгууллагын санал, тайлбар	Гаргасан шийдвэр
1	Завхан аймгийн Засаг даргын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл дүнмэлт өгөх аудит	Аймаг, сумдын орон нутгийн засгийн сан, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудын төлөвлөгт, гүйцэтгэлийг зөвхөн амжилттай, харингүй ажлаагуулсан сангийн сангийн аргын талынтайг бодолтой төлөвлөсөгүй	-	Зөвлөх өгөх	Хүлээн зөвшөөрсөн	Зөвлөх өгөх
2		Төрийн газрын Сангуу, төрийн сангийн хэлтэс нь өмнөх аудитаар илэрсэн зөрчлийн дүнгийн гаргах татварын орлогын гүйцэтгэлийг 10 нар төгрөгд татварын газрын мэдээлэл 114.8 сая төгрөгээр заруулаг болон хэдгэлдэгийн хүрлийн орлогыг хүү төрүүллийн орлогыг төлөвлөсөн	114.8	Албан шардлага өгөх	Хүлээн зөвшөөрсөн	Албан шардлага өгөх
Дүн			114.8			

Бэлтгэсэн:

Аудитор

Хянасан:

Ахлах аудитор

Чанарын хэмэлт зөвхөн:

Аудитын илгээгч

Т.Басанзориг
Ш.Оюунсүрэн
Х.Бордбаатар

ATA114 0019376
072 24207

Тэмдэглэн зөвшөөрсөн:

Сангуу, төрийн сангийн хэлтэсийн дарга

Сангуу, төрийн сангийн хэлтэсийн төсвийн нэгдэлтгэн

Б.Чардабал



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/18

Улиастай

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны
нэгдсэн төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх
аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх" аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг аймгийн Засаг дарга (Г.Өнөрбаяр)-д хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг даргад зөвлөсүгэй.
4. Аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аудитор (Г.Баасанжаргал)-д даалгасугай.
5. Аудитын ажлын нотлох баримтыг 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитор (Г.Баасанжаргал)-д үүрэг болгосугай.



Д.БАТ-УНДРАА

(D)/2024 он/тушаал

013010046